



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 2/250


Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 7 дугаар зүйлийн 7.3, 13 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-ны 1.1 дэх заалт, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ёс зүйн хорооны ажиллах журам"-ын 2.4, 2.5, 3.8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Зам, тээврийн хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.10.1, 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ёс зүйн дэд хорооны ажиллах журам батлагдсантай холбогдуулан "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 7 гишүүнтэй байхаар тогтоож, үйлдвэрийн газрын албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Ёс зүйн дэд хорооны даргыг хорооны хурлаар хэлэлцэж, сонгохыг дэд хорооны гишүүдэд даалгасугай.
3. Албан хаагчийн ёс зүйн асуудлаар гаргасан гомдол, мэдээллийг хууль болон холбогдох дүрэм, журамд заасны дагуу шалган шийдвэрлэж, журмын хэрэгжилтийг ханган, биелэлтийг тайлагнаж ажиллахыг Ёс зүйн дэд хороонд үүрэг болгосугай.
4. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэж, дарга, нарын бичгийн дарга, гишүүдэд урамшууллыг холбогдох журамд заасны дагуу тооцож олгохыг Санхүү хөрөнгө оруулалтын алба (Э.Ганбаатар)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тус хорооны гишүүдийг чадавхжуулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны хэлтэс (Д.Баярдорж)-т тус тус даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/32, А/34 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ



Д.ОЮУНБОЛД

1625022991

“Зам тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын
захирлын 2025 оны 10 дугаар сарын 14
-ны өдрийн 1/..... дугаар тушаалын
хавсралт 1/250



“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын
Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн

Д.Баярдорж

Захиргааны хэлтсийн дарга

Э.Батсүх

Барилга угсралт хяналтын хэлтсийн
дарга

Т.Хоролсүрэн

Эрдэм шинжилгээ судалгаа,
инновацийн хэлтсийн дарга

Г.Анхцэцэг

Авто замын төв лабораторийн эрхлэгч

Ц.Батгэрэл

Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн
дарга

Э.Лхамсүрэн

Авто замын ашиглалтын хэлтсийн
Төлөвлөлт хариуцсан ахлах
мэргэжилтэн

Б.Лхагвадорж

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн
магадлал, стандарт, норм нормативын
хэлтсийн Төсвийн үнэ бүрдэл хариуцсан
мэргэжилтэн